МЭДЭЭ · 2025 оны 3-р сарын 13

"ҮЙЛДЛЭЭ ХЯНАЯ" НӨЛӨӨЛЛИЙН АЯНЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ



Төв аймгийн прокурорын газар, тус аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Үйлдлээ хяная" нөлөөллийн аяныг 2025 оны 3 дугаар сарын 06-ны өдрөөс эхлүүллээ.

Тус аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2024 онд Авлига, албан тушаалын 9 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 33 хувиар өссөн байна.

Дээрх аяны хүрээнд иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, уулзалтуудыг үе шаттай зохион байгуулахаас гадна авлига, албан тушаалын гэмт хэргийн хор уршиг, үр дагавар, хууль эрх зүйн зохицуулалтын талаар мэдээлэл өгөх зэрэг соён гэгээрүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулахаар төлөвлөжээ.

Энэ хүрээнд прокуророос аймаг, сумдын засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, төлөөлөгчид болон бусад төрийн байгууллагын албан хаагчдад авлига, албан тушаалын гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ярилцлага хийж, сургалт зохион байгуулсан байна.

"Үйлдлээ хяная" нөлөөллийн аян нэг сарын хугацаанд үргэлжилнэ.